



**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 8/16

Улаанбаатар хот

**Х.Бямбаад нэг удаагийн буцалтгүй
тусламж олгох тухай**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18, 16.5.5 дахь заалт, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк хаалттай хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.14 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 8.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн Ханхайн Бямбаад ар гэрийн гачигдал гарч төрсөн эцэг нь нас барсан тул нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

2.Дээрх зардалд 500,000 (Таван зуун мянга) төгрөгийг төсвөөс гаргахыг Ахлах нягтлан бодогч (Г.Ганцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.РАДНААБАЗАР



**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 2/17

Улаанбаатар хот

**Нэг удаагийн буцалтгүй тусламж
үзүүлэх тухай**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18, 16.5.5 дахь заалт, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк хаалттай хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.14 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 8.3.3 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Гэр бүлд нь шинээр хүүхэд мэндэлсэн баярт үйл явдлыг тохиолдуулан Маркетинг хариуцсан мэргэжилтэн Э.Энгүүнд нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсүгэй.

2.Тусламж үзүүлэхэд шаардагдах 300,000 (Гурван зуун мянга) төгрөгийг төсвөөс гаргахыг Ахлах нягтлан бодогч (Г.Ганцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.РАДНААБАЗАР



**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 8/27

Улаанбаатар хот

**Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх
тухай**

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэг, “Налайхын үйлдвэрлэл, технологийн парк” хаалттай хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Манаач, харуул Шийтэрдоржийн Батсүх, Бат-Очирын Ганбаатар нарт ахмадын баярын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлж тус бүр 100,000 (нэг зуун мянга) төгрөг олгосугай.

2. Дээрх зардалд шаардагдах 200,000 төгрөгийг төсвөөс гаргахыг Ахлах нягтлан бодогч (Г.Ганцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.РАДНААБАЗАР